

**МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 13

№ 26/ТУЗ/16

Улаанбаатар хот

“ Ногдол ашиг хуваарилах тухай ”

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.10, Компанийн Ногдол ашгийн бодлогын холбогдох заалт болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Монложистикс Холдинг” ХК-ийн 2025 оны санхүүгийн жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэхдээ нийт гаргасан хувьцааны тоо ширхэгээр тооцсон байх тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн №26/ТУЗ/12 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.
2. “Монложистикс Холдинг” ХК-ийн 2025 оны санхүүгийн жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 5.80 (таван төгрөг наян мөнгө) төгрөгөөр тогтоож, Компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 23,6 (хорин гурав аравны зургаа) хувийг буюу 2,269,152,832.60 (хоёр тэрбум хоёр зуун жаран есөн сая нэг зуун тавин хоёр мянга найман зуун гучин хоёр төгрөг жаран мөнгө) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон хуулийн этгээлийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр олгосугай.
5. Ногдол ашгийг тогтоосон хугацааны дотор хуваарилах, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, холбогдох татвар суутгах, ногдол ашиг хуваарилалтын тайланг зохицуулагч байгууллагуудад хүргүүлэх зэргээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, ТУЗ-д тайлагнаж ажиллахыг “Монложистикс Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**

Л.ГАНЗОРИГТ

